



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 347

Улаанбаатар хот

Эрх бүхий албан тушаалтныг
томилохыг зөвшөөрөх тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.2, Хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Үндэсний давхар даатгал” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Санжаа овогтой Наранцогт, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр Даржаа овогтой Насанжаргал, Цэндгомбо овогтой Болорчулуун, Пүрэвжав овогтой Эрдэнэбаатар, Аюуш овогтой Дэмбэрэл, Пүрэв овогтой Дорждагва, Янжив овогтой Батханд нарыг тус тус томилохыг зөвшөөрсүгэй.

2. Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж, даатгуулагчдын хууль ёсны эрх ашгийг хүндэтгэн ажиллахыг С.Наранцогт, Д.Насанжаргал, Ц.Болорчулуун, П.Эрдэнэбаатар, А.Дэмбэрэл, П.Дорждагва нарт үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН